



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, 6,969,309.78 (зургаан сая есөн зуун жаран есөн мянга гурван зуун есөн төгрөг далан найман мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 1 ширхэг автомашиныг худалдах 2 дахь удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Энхбат, "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын дарга Р.Цогтбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Үндсэн хөрөнгийг сэлбэгээр худалдсанаас олох орлогыг байгууллагад төвлөрүүлэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийн дүнг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ



0001579



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн  
23 дугаар тогтоолын хавсралт

"Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв"  
төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,  
акталж, данснаас хасах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ	
1	УАЗ-3962, УБЯ 84-65, суудлын, арал: 20155786	2002/2003	341,350	6,969,309.78	6,969,309.78	-	300,000.00	
				<b>6,969,309.78</b>	<b>6,969,309.78</b>	-	-	
<b>Нийт дүн</b>				(зургаан сая есөн зуун жаран есөн мянга гурван зуун есөн төгрөг далан найман мөнгө)				<b>(гурван зуун мянган төгрөг)</b>